



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2012 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

**“УБ Арт Фэйр-2012” үзэсгэлэн
зохион байгуулах тухай**

Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Иргэдийн оролцоо-Өрхийн хөгжлийг дэмжих жилийн зорилтын 1.1.4 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийн дэмжих болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, бэлэг дурсгалын чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах, аялал жуулчлалын салбараас ашиг олох боломжийг нэмэгдүүлэх зорилготой “УБ Арт Фэйр-2012” үзэсгэлэнг зохион байгуулахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.

Хоёр. “УБ Арт Фэйр-2012” үзэсгэлэнг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. “УБ Арт Фэйр-2012” үзэсгэлэнгийн төсөв болох 500 000 /таван зуун мянга/ төгрөгийг үзэсгэлэнг хамтран зохион байгуулах “М Арбат” ХХК-ны дансанд шилжүүлэхийг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. “УБ Арт Фэйр” үзэсгэлэнг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc.\tushaal\.

115050000050

ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ:

Үзэсгэлэнг зохион байгуулахад шаардагдах нийт зардал 1,790,000 /Нэг сая долоон зуун ерэн мянган төгрөг/ төгрөгийг Нийслэлийн Аялал жуулчлалын газар хариуцана

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Занабазарын нэрэмжит дүрслэх урлагын музей
- Дизайн парк
- СУИС, Дүрслэх урлагийн сургууль

ШАГНАЛ:

Үзэсгэлэнд оролцох уран бүтээлчийн туурвисан бүтээл нь үндэсний соёл, дүрслэх урлалыг илэрхийлсэн, шинэ санаа бүхий агуулсан бүтээл байх ба оролцсон уран бүтээлчидэд өргөмжлөл, дурсгалын зүйлс гардуулна.

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Улирлын хамааралыг багасгаж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулна.
- Үндэсний соёл урлаг, дүрслэх урлагийг сурталчилан дэмжих жил тутамд зохиогдох Олон улсын "Уламжлалт үзэсгэлэнтэй" болно.
- Уран бүтээлчид бүтээлээ олон нийтэд толилуулах таатай нөхцөлөөр хангагдана
- Сургалт-семинар зохион байгуулснаар гар урчуудад шинэлэг санаа болон бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах

ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар чөлөөт уран бүтээлчдийг дэмжиж, энэ чиглэлээр оюутан залуусыг бэлтгэн гаргадаг их дээд сургууль, коллежийг дэмжих зорилгоор "UB Art Fair" үзэсгэлэн яармагийг уламжлал болгон зохион байгуулснаар:

- Нийслэлийн аялал жуулчлалыг шинэ шатанд гаргах Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтсан соёл урлагийн томоохон арга хэмжээтэй болох.

- Гадаад дотоодын жуулчдын амралт чөлөөт цагийг тав тухтай өнгөрөөх түүнчлэн хүүхэд залууст шинэ цагийн үндэсний гар урлалын төрлийг таниулж энэ чиглэлээр хичээллэхэд нь дөхөм болох.

УГ ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН БАЙГУУЛСНААР ГАРАХ ҮР ДҮН

- Дэлхийн Аялал жуулчлалын өдрийг угтсан уламжлалт соёлын томоохон эвэнт арга хэмжээтэй болно.
- Жуулчдад зориулсан төрөл бүрийн соёлын урлагийн эвэнт арга хэмжээнүүдийг зохион байгуулах боломжтой болно.
- Уран бүтээлчид, гар урчуудын үйл ажиллагааг дэмжих замаар соёлын аялал жуулчлалыг төвийн бүс нутагт хөгжүүлэхэд түлхэц болно.
- Үндэсний соёл урлагийг сурталчилж гар урлал, арьсан урлаг, зураасан зураг, уран бичлэгийн урлагийг хотын иргэд хүүхэд залуучуудад таниулна.
- Чөлөөт уран бүтээлчдийг дэмжин Олон улсын уран бүтээлчидтэй туршлага солилцох замаар үзэсгэлэнг жил бүр зохион байгуулна.
- Хотын аялал жуулчлалын орлогын эх үүсвэр нэмэгдэнэ.
- Аялал жуулчлалын идэвхитэй улирлыг уртасгах зорилгыг хэрэгжүүлнэ.

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.БАЯСГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН



Ш.УНДАРМАА




“UB ART FAIR 2012” ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ҮЗЭСГЭЛЭНГ
ЗОХИОН БАЙГУУЛЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэрс	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хэвлэлийн зардал /урилга/	50 ш	500	25 000
2	Өргөмжлөл эх бэлтгэл	1ш	25 000	25 000
3	Өргөмжлөл	10 ш	20 000	200 000
4	Сургалт	1 удаа		250 000
	Нийт			500 000

Хянасан:

Нягтлан

 - П.Ариунаа

Төсөв гаргасан:

Ахлах мэргэжилтэн

 Г.Баясгалан